



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/150

Алтай хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарлаж авлигатай тэмцэх "Шүүр" ажиллагааг хэрэгжүүлэхээр ирүүлсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Мөнхжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүн:

Б.Золжаргал (Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Баатарзориг (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Л.Хаш-Эрдэнэ (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Э.Буянтөгс (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Ичинхорол (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

З.Жаргалтуяа (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Итэшмаа (Төрийн албаны зөвлөлийн Говь-Алтай аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

2. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн хүрээнд шүүр ажиллагааг зохион байгуулж, дүнг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (С.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР